ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Цөмийн физикийн судалгааны төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2023/100/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2023 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг<br>Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Аудитор: Ч.Дашдаваа<br>Утас: 261885 Цахим хаяг: dashdavaach@audit.gov.mn<br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн Захирал С.Тунгалаг<br>Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.02.24 № 07/400
танай ____________-ны № ____________-т

ЦӨМИЙН ФИЗИКИЙН СУДАЛГААНЫ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.БОЛОРТУЯА ТАНАА

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цөмийн физикийн судалгааны төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цөмийн физикийн судалгааны төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 3,388.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлалын 3.10 заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэ зөв байх, оршин байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Цөмийн физикийн судалгааны төв нь цөмийн физикийн суурь, цөмийн эрчим хүч, цөмийн түлш, цөмийн болон цацрагийн технологийн судалгаанууд болон сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээний байгууллага юм.

**Аудитын гол асуудал**

Шинжлэх ухаан технологийн сангаас Цөмийн физик судалгааны төвийн 2022-2024 онд хэрэгжүүлэх "Цөмийн кластержилт ба нейтрон-бодисын харилцан үйлчлэлийн судалгаа" төсөлд 7,711.9 мянган, "Эмнэлгийн зориулалт бүхий позитрон цацаргагч

изотопуудыг гарган авах цөмийн урвалын судалгаа" төсөлд 8,504.6 мянган төгрөгийг авч, зарцуулан нэмэлт санхүүжилтийн дансанд тайлагнасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Цөмийн физикийн судалгааны төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч нь МУИС-ийн Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээнд заасан, гүйцэтгэлийн 8 шалгуур үзүүлэлтийг 100.0 хувь гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **104,154,681.58** | **73,845,895.88** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **-** | **-** |
| **32** | **БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | **-** | **-** |
| **33** | **АВЛАГА** | **31,221,255.70** | **-** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 59,028.70 | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 31,162,227.00 | - |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **-** | **-** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **72,933,425.88** | **73,845,895.88** |
| **351** | **Түүхий эд материал** | **70,546,151.04** | **71,513,221.04** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 70,546,151.04 | 71,513,221.04 |
| **354** | **Хангамжийн материал** | **2,387,274.84** | **2,332,674.84** |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 54,600.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 2,332,674.84 | 2,332,674.84 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | **-** | **-** |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **483,694,350.13** | **393,422,900.02** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | **-** | **-** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **483,694,350.13** | **393,422,900.02** |
| **392** | **Биет хөрөнгө** | **483,408,350.13** | **392,056,900.02** |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 641,232,009.03 | 643,731,909.03 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (161,812,778.29) | (263,839,547.08) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8,667,810.00 | 8,667,810.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,738,690.61) | (6,563,271.93) |
| 39217 | Ном | 1,060,000.00 | 10,060,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **286,000.00** | **1,366,000.00** |
| 39301 | Программ хангамж | 2,013,408.76 | 3,213,408.76 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,727,408.76) | (1,847,408.76) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **587,849,031.71** | **467,268,795.90** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,489,400.00** | **3,296,071.83** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 2,489,400.00 | 3,296,071.83 |
| **413** | **Өглөг** | 2,489,400.00 | 3,296,071.83 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 68,098.83 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 733,173.00 |
| **4136** | **Бусад өглөг** | **2,489,400.00** | **2,494,800.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 2,489,400.00 | 2,494,800.00 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **585,359,631.71** | **463,972,724.07** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 585,359,631.71 | 463,972,724.07 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 177,196,868.00 | 177,196,868.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 177,196,868.00 | 177,196,868.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 408,162,763.71 | 286,775,856.07 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (9,319,698.43) | 408,162,763.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 417,482,462.14 | (121,386,907.64) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **587,849,031.71** | **467,268,795.90** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **845,051,890.67** | **368,647,800.00** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **437,718,590.67** | **1,200,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 368,345,369.63 | 1,200,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 368,345,369.63 | 1,200,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 368,345,369.63 | 1,200,000.00 |
| **122** | **Тусламжийн орлого** | 69,373,221.04 | - |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 69,373,221.04 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **407,333,300.00** | **367,447,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 341,533,300.00 | 351,230,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 341,533,300.00 | 351,230,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 65,800,000.00 | 16,217,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 65,800,000.00 | 16,217,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **427,569,428.53** | **490,034,707.64** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **427,569,428.53** | **490,034,707.64** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 400,932,915.41 | 489,964,131.85 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 267,428,383.53 | 299,994,894.74 |
| 210101 | Үндсэн цалин | 225,446,483.23 | 244,357,211.53 |
| 210102 | Нэмэгдэл | 27,431,905.30 | 38,446,264.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,549,995.00 | 16,992,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 199,419.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,671,261.73 | 35,776,707.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,698,162.12 | 25,626,696.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,749,883.91 | 2,892,821.39 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,139,427.19 | 2,399,959.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 333,780.70 | 441,566.43 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,750,007.81 | 4,415,663.25 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,038,834.42 | 13,151,573.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,260,797.71 | 8,830,249.33 |
| 210302 | Түлш, халаалт | 1,778,036.71 | 4,321,323.67 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,687,900.00 | 1,376,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,519,200.00 | 996,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 45,500.00 | 177,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 123,200.00 | 202,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 2,945,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 2,945,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 5,230,250.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 5,230,250.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 2,500,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 2,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,369,219.50 | 24,844,127.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,643,419.50 | 22,162,227.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,494,800.00 | 2,500,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 231,000.00 | 181,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 72,737,316.23 | 104,144,280.11 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 1,172,930.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 72,737,316.23 | 102,971,350.11 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 26,636,513.12 | 70,575.79 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 26,636,513.12 | 70,575.79 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 26,636,513.12 | 70,575.79 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **417,482,462.14** | **(121,386,907.64)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **417,482,462.14** | **(121,386,907.64)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **407,333,300.00** | **367,447,800.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **-** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **407,333,300.00** | **367,447,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 341,533,300.00 | 351,230,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 341,533,300.00 | 351,230,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 65,800,000.00 | 16,217,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 65,800,000.00 | 16,217,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **407,333,300.00** | **367,447,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **407,333,300.00** | **367,447,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **380,696,786.88** | **367,377,224.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 267,428,383.53 | 297,022,300.00 |
| 210101 | Үндсэн цалин | 219,648,551.76 | 241,384,616.79 |
| 210102 | Нэмэгдэл | 31,651,838.19 | 38,446,264.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,127,993.58 | 16,992,000.00 |
| 210104 | Урамшуулал | - | 199,419.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,730,290.43 | 38,622,174.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,757,190.82 | 28,365,036.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,749,883.91 | 2,999,949.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,139,427.19 | 2,399,959.10 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 333,780.70 | 441,566.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,750,007.81 | 4,415,663.25 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,997,834.42 | 12,418,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,036,779.60 | 8,097,076.33 |
| 210302 | Түлш, халаалт | 2,961,054.82 | 4,321,323.67 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 511,100.00 | 1,322,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 246,800.00 | 996,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 141,100.00 | 123,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 123,200.00 | 202,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 5,085,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 5,085,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 7,730,150.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 7,730,150.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 2,500,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 2,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 67,029,178.50 | 2,676,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 65,798,178.50 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | 2,494,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 231,000.00 | 181,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **26,636,513.12** | **70,575.79** |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 26,636,513.12 | 70,575.79 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 26,636,513.12 | 70,575.79 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 177,196,868.00 | (9,319,698.43) | 167,877,169.57 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **177,196,868.00** | **(9,319,698.43)** | 167,877,169.57 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | 417,482,462.14 | 417,482,462.14 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **177,196,868.00** | **408,162,763.71** | 585,359,631.71 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **177,196,868.00** | **408,162,763.71** | 585,359,631.71 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | (121,386,907.64) | (121,386,907.64) |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **177,196,868.00** | **286,775,856.07** | 463,972,724.07 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 351,230,800.00 | 351,160,774.21 | 70,025.79 | 99.9 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 351,230,800.00 | 351,160,774.21 | 70,025.79 | 99.9 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 351,230,800.00 | 351,160,774.21 | 70,025.79 | 99.9 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 297,022,300.00 | 297,022,300.00 | - | 100.0 |
| Үндсэн цалин | 226,668,600.00 | 241,384,616.59 | (14,716,016.59) | 106.5 |
| Нэмэгдэл | 61,572,100.00 | 38,446,265.91 | 23,125,834.09 | 62.4 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 8,781,600.00 | 16,991,998.50 | (8,210,398.50) | 193.5 |
| Урамшуулал | - | 199,419.00 | (199,419.00) | 100.0 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,692,200.00 | 38,622,174.21 | 70,025.79 | 99.8 |
| Тэтгэврийн даатгал | 27,227,800.00 | 28,365,036.43 | (1,137,236.43) | 104.2 |
| Тэтгэмжийн даатгал | 2,866,100.00 | 2,999,948.93 | (133,848.93) | 104.7 |
| ҮОМШӨ-ний даатгал | 2,292,900.00 | 2,399,959.17 | (107,059.17) | 104.7 |
| Ажилгүйдлийн даатгал | 573,200.00 | 441,566.43 | 131,633.57 | 77.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 5,732,200.00 | 4,415,663.25 | 1,316,536.75 | 77.0 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,418,400.00 | 12,418,400.00 | - | 100.0 |
| Гэрэл, цахилгаан | 7,207,700.00 | 8,097,076.33 | (889,376.33) | 112.3 |
| Түлш, халаалт | 5,210,700.00 | 4,321,323.67 | 889,376.33 | 82.9 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 421,400.00 | 421,400.00 | - | 100.0 |
| Бичиг хэрэг | 95,400.00 | 95,400.00 | - | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 123,300.00 | 123,300.00 | - | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 202,700.00 | 202,700.00 | - | 100.0 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,676,500.00 | 2,676,500.00 | - | 100.0 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,494,800.00 | 2,494,800.00 | - | 100.0 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 181,700.00 | 181,700.00 | - | 100.0 |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** | - | 0.0 |
| **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | - | - | - | 0.0 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 351,230,800.00 | 351,160,774.21 | (70,025.79) | 99.9 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 351,230,800.00 | 351,160,774.21 | (70,025.79) | 99.9 |
| Улсын төсвөөс санхүүжих | 351,230,800.00 | 351,160,774.21 | (70,025.79) | 99.9 |
| **БУСАД ЭХ ҮҮСВЭР** | - | - | - | - |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - | - | - |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - | - | - |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 20 | 20 | - | 100.0 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 18 | 18 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 1 | 1 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **16,217,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **16,217,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | 16,217,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **-** | 900,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | **-** | 900,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **-** | 5,085,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | **-** | 5,085,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-** | 7,730,150.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | **-** | 7,730,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **-** | 2,500,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | **-** | 2,500,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **-** | **-** |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 16,217,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | - |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **-** | **-** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 147,736.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 51,360.0 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 87,784.9 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 8,591.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөв.

Аудитаар илэрсэн 96,376.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 3,388.4 мянган төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын тайланд 200.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. | 1 | 200.4 | - | - | 1 | 200.4 | 1 | 200.4 | - | - | - | - |
| 2 | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын эхний үлдэгдэл 59.0 мянган төгрөгийг цалингийн зардлаар бүртгэж тайлагнасан. | 1 | 302.9 | - | - | 1 | 302.9 | 1 | 302.9 | - | - | - | - |
| 3 | Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээс 243.9 мянган төгрөгөөр илүү бүртгэж, тайлагнасан. | 1 | 243.9 | - | - | 1 | 243.9 | 1 | 243.9 | - | - | - | - |
| 4 | Төсвийн гүйцэтгэлийн тайланд 50,856.7 мянган төгрөгийн тохируулгыг бэлтгэж, тайлагнаагүй. | 1 | 50,856.7 | - | - | 1 | 50,856.7 | 1 | 50,856.7 | - | - | - | - |
| | **Дүн** | **5** | **51,603.9** | **-** | **-** | **5** | **51,603.9** | **5** | **51,603.9** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 3 байгууллагын 8,591.1 мянган төгрөгийн и-баримт дутуу бүртгэгдсэн байна. | 1 | 8,591.1 | - | - | - | - | 1 | 8,591.1 | - | - | - | - |
| 2 | Байгууллагын захирлын үүрэг гүйцэтгэгчийн "Эд хөрөнгийн тооллого явуулах тухай" 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/37 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй, 73,845.9 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг хийгээгүй, тооцоог бодоогүй байна. | 1 | 73,845.9 | - | - | 1 | 73,845.9 | - | - | - | - | - | - |
| 3 | Сангийн сайдын “Заавар батлах тухай” 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтын дагуу “Агуулахын бүртгэл” хөтлөөгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| 4 | Өмнөх оны 13,939.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардалд анхан шатны баримтгүйгээр бүртгэж тайлагнасан байна. | 1 | 13,939.0 | - | - | 1 | 13,939.0 | - | - | - | - | - | - |
| 5 | Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 57 нэр төрлийн эд хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж бүртгээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| | **Дүн** | **4** | **96,376.0** | - | - | **2** | **87,784.9** | **3** | **8,591.1** | - | - | - | - |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөгөөр/*

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих орлогын 351,230.8 мянган төгрөгийн 13, зарлагын 16,217.0 мянган төгрөгийн 2, бусад 14,525.0 мянган төгрөгийн 5, нийт 381,972.8 мянган төгрөгийн 20 мэдээллээс 8 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 11 мэдээллийг байршуулаагүй байна. | 1 | 136,912.6 | - | - | 1 | 136,912.6 | - | - |
| | **Дүн** | **1** | **136,912.6** | - | - | **1** | **136,912.6** | - | - |
| | **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| 1 | Цахим дэлгүүрт байршуулсан Dell Optiplex 3000 i5" компьютерыг, Ерөнхий гэрээ байгуулалгүй "Пи си молл" ХХК-аас худалдан авсан байна. | 1 | 2,499.9 | - | - | 1 | 2,499.9 | - | - |
| | **Дүн** | **1** | **2,499.9** | - | - | **1** | **2,499.9** | - | - |
| | **Нийт дүн** | **2** | **139,412.5** | - | - | **2** | **139,412.5** | - | - |

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 24 №262/А0150053 Улаанбаатар хот
СНАГ-2023/100/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цөмийн физикийн судалгааны төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Байгууллагын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн "Эд хөрөнгийн тооллого явуулах тухай" 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/37 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй, 73,845,895.88 төгрөгийн бараа материалын тооллогыг хийгээгүй, тооцоог бодоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-т "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;" үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "*Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын тооллогыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, тооцоог бодож байх, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цөмийн физикийн судалгааны төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болортуяа, нягтлан бодогч Б.Цагаанхүү нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ

ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ С.ТУНГАЛАГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 дугаар сарын 24 № 263/A0150053 Улаанбаатар хот

СНАГ-2023/100/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цөмийн физикийн судалгааны төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Өмнөх оны 13,939,000.00 төгрөгийн авлагын үлдэгдлийг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардалд анхан шатны баримтгүйгээр бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" нэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "*Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтгүйгээр ажил, гүйлгээг бүртгэж тайлагнахгүй байх, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цөмийн физикийн судалгааны төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болортуяа, нягтлан бодогч Б.Цагаанхүү нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ С.ТУНГАЛАГ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 дугаар сарын 24 №264/А0150053 Улаанбаатар хот
СНАГ-2023/100/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цөмийн физикийн судалгааны төвийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих орлогын 351,230,800.00 төгрөгийн 13, зарлагын 16,217,000.00 төгрөгийн 2, бусад 14,525,000.00 төгрөгийн 5, нийт 381,972,800.00 төгрөгийн 20 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 11 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын *4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээлэх, зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цөмийн физикийн судалгааны төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болортуяа, нягтлан бодогч Б.Цагаанхүү нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР — Д.ЭНХДАЛАЙ
ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ — С.ТУНГАЛАГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*